



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/658

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XII хуралдааны 14 тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 26 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оны Монголд Зочлох жил болгон зарласантай холбогдуулан “Хөвсгөл аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, нутгийн иргэдэд суурилсан Эко аялал жуулчлал 2024 оны ажлыг төлөвлөх хүрээнд хийгдэж буй хэлэлцүүлэг”-ийн зардалд 4.000.000 (дөрвөн сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. “Хөвсгөл аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, нутгийн иргэдэд суурилсан Эко аялал жуулчлал 2024 оны ажлыг төлөвлөх хүрээнд хийгдэж буй хэлэлцүүлэг”-ийн ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран зохион байгуулж, тайлагнан ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т, Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж2023

6712011508